

ТЕНДЕРИЙН УРИЛГА

2013 оны 04 дугаар сарын 29

Тендер шалгаруулалтын нэр: **ДЦС-2-ын Цахилгаан тоноглолын шинэчлэл (Улаанбаатар)-ийн ажил**

Тендер шалгаруулалтын дугаар: **ХААГ-А-2013/ХҮIII-18**

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг **Худалдан авах ажиллагааны газар** нь эрх бүхий тендерт оролцогчдоос **ДЦС-2-ын Цахилгаан тоноглолын шинэчлэл (Улаанбаатар)** ажлыг гүйцэтгэх тухай *цахим тендер* ирүүлэхийг урьж байна.

Энэхүү ажлын тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.meps.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг авна уу. Мөн цахим тендер шалгаруулалтыг Сангийн сайдын 2013 оны 07 дугаар тушаалаар батлагдсан “Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журам”-ын (www.e-procurement.mn дээр байгаа) дагуу зохион байгуулж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдэл бүрийг нь **20,000 (хорин мянга)** төгрөгийг цахим хэлбэрээр төлж худалдан авч болно.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 3 жилийн аль нэг жилд хийж гүйцэтгэсэн барилгын ажлын нийт мөнгөн дүнгийн борлуулалтын хэмжээн нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 30 хувиас багагүй байна

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил (Тендерийн материалд санхүүгийн тайланг хавсарган ирүүлэх шаардлагагүй бөгөөд цахим систем Үндэсний Татварын Ерөнхий Газрын мэдээллийн сангаас тендерт оролцогчийн 2011, 2012 оны санхүүгийн тайланг цахим хэлбэрээр шалгана.)

Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Сүүлийн 3 жил буюу 2010-2012 онуудад хийж гүйцэтгэсэн ижил төстэй ажлын жагсаалтыг ирүүлнэ.

Тусгай зөвшөөрөл шаардлагатай бол тусгай зөвшөөрөл ирүүлэх эсэх: Тийм
0,4-35 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт тохируулга, дагалдах ажил үйлчилгээ гүйцэтгэх тусгай зөвшөөрөлтэй байх.

Тендерийн хамт **25,000,000 (хорин таван сая)** төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2013 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 15 цагаас өмнө** доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2013 оны 05 дугаар сарын 30 -ны өдрийн 15 цаг 20 минутад нээнэ.**

Гадаадын этгээд тендер ирүүлэх **эрхгүй.**

Монгол Улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрхийн зөрүү **тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

14913 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Их тойруу 80/1

Нэг цэгийн үйлчилгээ, Утас:70111090

www.e-tender.mn, www.procurement.gov.mn

www.meps.gov.mn, www.e-procurement.mn